



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 282

Улаанбаатар хот

┌ Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай ┐

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Компанийн тухай хуулийн 18, 20 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 5.3, 9.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “Хас банк” ХК-д “Тэнгэр санхүүгийн нэгдэл” ХХК-ийг нэгтгэх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулсныг Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд бүртгэж, тус компанийн нэг бүр нь 100 (нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 1,052,700,000 (нэг тэрбум тавин хоёр сая долоон зуун мянга) ширхэг хувьцааны өмчлөх эрхийг энэ тогтоолын хавсралтад заасан хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд баталгаажуулан бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д зөвшөөрсүгэй.

2. Компанийг өөрчлөн байгуулсан талаарх мэдээллийг хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд хүргэж, үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдөж, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж ажиллахыг “Хас банк” ХК (Г.Цэвэгжав)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ



1518000616

Санхүүгийн зохицуулах хорооны
2025 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн
282 дугаар тогтоолын хавсралт

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Бүртгэлийн дугаар	Хувьцааны тоо ширхэг
1	МАК Инвест Эс Жи Пи Ти И Эл Ти Ди (MAK Invest SG Pte. Ltd.)	202444045G	203,864,933
2	Олон Улсын Санхүүгийн Корпорац (International Finance Corporation)	-	175,028,025
3	ОРИКС Корпорац (ORIX Corporation)	0104-01-006942	171,366,429
4	Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (European Bank for Reconstruction and Development)	-	131,543,137
5	Канадын Үндэсний Банк (National Bank of Canada)	1141418286	107,194,412
6	Ронок Партнерз КэйЭфТи (Ronoc Partners Kft.)	26146119-2-42	103,459,739
7	Монголия Файненшл Сервизис Пти. Лтд (Mongolia Financial Services Pte. Ltd.)	201317348H	67,531,041
8	Легал Өүнер Триодос Фандс Би. Ви. (Legal Owner Triodos Funds B.V)	-	38,024,639
9	М.Болдоо	111074461823	1,042,868
10	Ч.Ганболд	111904401456	944,777
11	Олон нийт	-	52,700,000
Нийт дүн			1,052,700,000